

2

ҮНДЭСНИЙ БАЯЛАГ ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ҮНДЭС МӨН

Д. Цэрэнпил

Зах зээлийн эдийн засгийн үйл явц, үр дүн нь зөвхөн бараа үйлчилгээний бизнесийн урсгалыг илэрхийлсэн үйл ажиллагаагаар хязгаарлагдахгүй, харин удаан хугацааны хуримтлалын үүндээс үнэлэх ёстой.

Үндэсний баялагийн хэмжээ нь улс орны эдийн засгийн хүч чадал, чадавхийг тодорхойлсон макро эдийн засгийн онолын судалгааны чухал асуудал юм.

Үндэсний баялагийн өсөлтөд нийгмийн нөхөн үйлдвэрлэлийн үр ашиг тусгалаа олно. Адам Смит 233 жилийн өмнө "Ард түмний баялаг" зохиолдоо үндэсний баялагийн судалгаанд гарааны үндсийг тавьснаас хойш энэ асуудал шинжлэх ухааны судалгаанд шаардлага бүхий судлах зүйл болжээ.

Үндэсний баялаг, түүний элементүүдийг тодорхойлолгүйгээр Монгол улс зах зээлийн харилцаанд шилжих нэн тулгамдсан:

- төрийн өмчийг задлах, хувьчлах, өмчийн олон хэлбэрийг хослуулан хөгжүүлэх, хувийн секторыг бэхжүүлэх, ирээдүйн хуримтлалыг бүрдүүлэх, татварын бодлого, улсын болон орон нутгийн бие даасан байдлыг хангах зэрэг олон асуудлыг ул суурьтай зохистой шийдвэрлэх боломжгүй.

I. Үндэсний баялаг

Үндэсний баялагийн талаар өнөөг хүртэл манайд нэгдмэл ойлголт байхгүй, түүний ашиглалтад шинжлэх ухааны гүнзгий судалгаа хийгдээгүй, одоо нээлттэй асуудал хэвээр байна.

Үндэсний баялаг, эдийн засгийн чадавхи түүний бүрэлдэхүүн элементүүдийн харилцан холбоо, нөхөн үйлдвэрлэлийн үйл явцад тэдгээрийн ролийг тодорхойлох нь манай орны эдийн засгийн макро, микро төвшинд цаашдын хөгжлийн стратегийг

боловсруулах түүний нөхцөл боломжийн магадлалыг тооцоход чухал ач холбогдолтой.

Үндэсний баялгийн өнөөгийн шинж төлөв нь: нэгдүгээрт, эдийн засгийн үйл ажиллагааны төрөл бүрийн хүрээ, өмчийн олон хэлбэр, аж ахуйн янз бүрийн хэвшилд бий болсон бодит боломж, хоёрдугаарт, бэлэн байгаа нөөц баялгийн бүрдүүлэлт, ашиглалт, гуравдугаарт, нөөцийн нөхөн үйлдвэрлэл, ашиглалтын үйл явцад хүмүүсийн хооронд үүсч байгаа харилцааны (эдийн засгийн, үйлдвэрлэлийн харилцааны) хэлбэр: дөрөвт, материаллаг ба оюуны баялагийн удирдлага, маркетингийн ухааны төлөвшил, тэдгээрийг эзэмших чадвар, арга зүй зэргээр тодорхойлогдоно.

Энэ өгүүлэлдээ Монгол зах зээл рүү хэдий хэмжээний үндэсний баялагтай, түүхий эд ашиглалт ямар байгаагаас гарагаа эхлэв, цаашилбал үр ашгийг нь хэрхэн дээшлүүлэх вэ гэдгийг судлах оролдлого хийлээ.

Зах зээлийн нөхцөлд үндэсний үйлдвэрлэлийн үр ашиг, эдийн засгийн чадавхийн үнэлгээний хооронд нягт холбоотой. Эдийн засгийн чадавхийн элементэд: үндэсний баялаг, шинжлэх ухаан, боловсролын чадавхи хамаарна.

Манай оронд байгаа үндэсний баялаг нь: эдийн биш баялаг – хүн ам, байгалийн нөөц, газар, эрдэсийн нөөц, ой ба ан амьтны нөөц, материаллаг нөөц (үндсэн ба эргэлтийн капитал, өрх гэрийн аж ахуй) гэсэн биет нөөцийн гурван үндсэн элементийг өөртөө агуулна. Үүнийг үндэсний баялагын бүрдэлт, ашиглалтын бүтэц өсөлтийн агуулгын загвараар харуулав (бүдүүвч 1).

1. Хүн ам. Энэ нь зөвхөн тооны хувьд төдийгүй, түүний бүх талыг тодорхойлогч чанар (бүрэлдэхүүн, хүн амын идэвхитэй хэсэг, хөдөлмөрийн нөөц, соёл-боловсролын түвшин, сэтгэл зүйн байдал, ёс суртахууны түвшин, шинжлэх ухааны чадавхи, оюуны өмч)-ийг харуулна.

Хүн амын бүрэлдэхүүн, хөдөлмөрийн идэвхижилтийн
зарим үзүүлэлт (мян.хүн %)

№		1991	1995	1998
1	Хүн ам	2187.2	2317.5	2420
2	Хөдөлмөрийн насны хүн	1003.6	1186.7	2420.0
3	Эдийн засгийн идэвхитэй хүн ам: Үүнээс			
	ажиллагчид	851.1	839.8	859.3
	ажилгүйчүүд	795.7	795.7	809.5
		55.4	45.1	49.8
4	Ажиллах хүчний оролцооны түвшин (%)	84.8	70.8	68.4
5	Ажил эрхлэлтийн түвшин (%)	79.1	67.0	64.4
6	Ажилгүйдлийн түвшин (%)	6.5	5.4	5.8

Манай орны хүн ам зүй эдийн засагт хамгийн хүчтэй нөлөө бүхий хүчин зүйл юм. Сүүлийн 9 жилд хүн ам 10.6 хувь, хөдөлмөрийн нөөц 25.2 хувь өсч, сүүлчийнх нь өсөлтийн хурд хоёр дахин илүү байна.

Хүн бол оюуны чадавхийг эзэмдсэн нийгмийг удирдан хөтлөх бүтээлч сэтгэх чадварыг өөртөө шингээсэн элемент мөн. Манай орны эдийн засгийн төрөл бүрийн секторт ажиллагчдын 30 гаруй хувь нь дээд, тусгай дунд боловсролтой, нийт ажиллагчдын 90 шахам хувь нь ямар нэгэн боловсролтой, үүний дотор дийлэнх нь бүрэн дундаас дээш боловсролтой, мэргэжилтэй байна. Энэ нь манайд оюутны зохих чадавхи, түүний үндэс суурь бий болсныг харуулна. Шинжлэх ухаан-техник нь хүн амын оюуны баялагийн санг илэрхийлэх, хөгжлийн гол чадавхи юм. Зах зээлийн эдийн засгийн харилцаа гүнзгийрэх тутам эрдэм оюуны чадавхийг дээд зэргээр үнэлэх, ашиглах явдал улам өргөн тавигдана. Энэ бүхэн нь манайд байгаа зөвхөн тоон үзүүлэлт юм. Харин оюуны чадавхийн чанарын түвшин, өгөөжөөр бусад оронтой зэрэгцүүлэхэд ихээхэн хоцорч яваа.

Есөн жилд ажиллагсадын тоо дөнгөж 1.8 хувь өсөж, ажил эрхлэлтийн түвшин 15 хувиар буурсан. Хөдөлмөрийн биржид бүртгэгдсэн ажилгүйчүүдийн тоо буурсан гэж статистик үзүүлдэг. Үүний цаана далд буюу бүртгэгдээгүй ажилгүйчүүд хоёр зуу гаруй мянган хүн байгаа. Энэ бол хүн амтай холбоотой эдийн засгийн чадавхийн ашиглалт буурч байгааг харуулж байна.

1. Манай орны онгон төрхөөрөө байгаа өргөн уудам нутагтай, түүнд эрдэс түүхий эдийн баялаг нөөцтэй. Эдийн засгийн чадавхийн бүрэлдэхүүн гол элемент үндэсний баялаг мөн. Манай улсын өнөө ба ирээдүйн хөгжилд нэн чухал үүрэг гүйцэтгэнэ.

Үүнийг ирээдүй, хойч үедээ үлдээх өв гэж хэлж болно. Энэ нөөц нь түүний хэмжээ, газарзүйн байршил, ашигт малтмал (нээгдсэн, нээгдээгүй), ой мод, усны нөөц, эдэлбэр газар, хөрс цаг уурын нөхцөл зэргээр тодорхойлогдоно. Геологийн хайгууль хийгдэж нээгдсэн байдлаас үзэхэд манай орон алт, мөнгө, төмөр, зэс, өнгөт холимог болон ховор металл, уран, нүүрс, нефть зэрэг газрын хэвлийн харьцангуй баялаг нөөцтэй юм.

Одоогоор зөвхөн илрүүлсэн ба ашиглаж байгаа нөөцөд 1991 онд Лондонгийн бирж дээр хийлгэсэн эдийн засгийн урьдчилсан үнэлгээгээр манайд олон зуун турбум ам. Долларын байгалийн баялагтай байна гэж үзсэн. Энэ талаар манайх харьцангуй арвин баялаг, асар их чадавхитай. 1998 оны байдлаар эрдэсийн бүтээгдэхүүн нь Дотоодын нийт бүтээгдэхүүний (ДНБ) бараг 14 хувийг, экспортын нийт орлогын 47 хувийг эзэлж байна. Гагцхүү яаж ашиглах, ямар үр ашиг олох вэ? гэдэг нь хамгаас чухал.

2. Үндэсний баялагийн гурав дахь гол элемент нь тус улсын нутаг дэвсгэр дээр хүний хөдөлмөрөөр бүтээгдэн, ашиглагдаж байгаа материалын үнэт баялаг юм. Тус орны өмчийн олон хэлбэр, аж ахуйн янз бүрийн секторт үйлдвэрлэлийн завсрын болон эцсийн хэрэглээ, хүн амын хувийн болон нийгмийн хэрэгцээнд зориулагдаж байгаа (үйлдвэрлэлийн бүх аппарат, үндсэн ба эргэлтийн капитал,

мал, үрийн сан, тээвэр, холбоо, агуулах г.м. дэд бүтцийн үйлдвэрлэлийн сан, орон сууц, нийгэм соёлын сан, шинжлэх ухааны байгууллагын хөрөнгө, түүх соёлын зүйлийн хуримтлал, бусад үнэт зүйлс, төр, хамт олон, хувь хүний мөнгөн хуримтлал зэрэг) материаллаг баялаг хамаарагдана. Манай орныг харьцангуй үйлдвэржсэн орчин үеийн техник технологи нэвтэрсэн эдийн засагтай гэж үзэж болно. 1998 онд явуулсан аж ахуйн нэгжийн тооллогонд нийт 15.9 мянган аж ахуй хамаарагджээ. Тэдгээрийн эзэмшилд 1516.7 тэрбум төгрөгийн үндсэн капитал (үндсэн сүрэг мал оролцоогүй), хэдэн зуун тэрбум төгрөгийн материаллаг эргэлтийн капитал байна. Нийлбэр дүнгээрээ тухайн жилд үйлдвэрлэсэн ДНБ-ээс 2 дахин их байна. Материаллаг үйлдвэрлэлийн хүрээнд үйлдвэрлэлийн үндсэн капитал 75.0 хувь, эргэлтийн капитал 96.0 хувь нь ашиглагдаж байна. Түүнчлэн ардын хувийн аж ахуйтанд 30 гаруй мал сүрэг бий.

Үүнээс гадна жилд үйлдвэрлэгдэж байгаа үндэсний нийт бүтээгдэхүүн, төрийн янз бүрийн төвлөрсөн сан, аж ахуйн нэгж, хүн амын мөнгөн хуримтлал (хадгаламж) зэрэг олон зуун тэрбум төгрөгийн мөнгөн нөөц бий. Энэ бүхэн нь Монголын ард түмний хөдөлмөрөөр бүтээгдсэн үндэсний баялаг юм. Манай орон дээрх гурван элементээс бүрдэж байгаа материаллаг ба оюуны нөөц-эдийн засгийн чадавхи дээр суурилж зах зээлийн харилцаанд шилжих гараагаа эхэлсэн.

Харин эдгээрээс нөхөн үйлдвэрлэлийн явцад шууд оролцуулж, ашиглагдаж байгаа биет нөөцөд:

- эдийн засаг, нийгмийн төрөл бүрийн салбарт хөдөлмөр эрхэлж, ажиллаж байгаа хүн ам (тэдгээрийн чанарын бүтцийн тодорхойлолт)
- аж ахуйн эргэлтэд оруулсан байгалийн нөөц, тэдгээрийн хэмжээ, чанарын бүтэц
- ашиглагдаж байгаа үйлдвэрлэлийн үндсэн ба эргэлтийн капитал, хэрэглээний зүйлс, нөөц капитал хамаарагдана.

Нэгэнт бүрэлдэн бий болсон үндэсний баялаг буюу эдийн засгийн чадавхи, түүний ашиглалт нь улс орноо эдийн засаг, нийгмийн хямралаас гаргах, тогтворжуулах, цаашдын хөгжлийг хангах үндсэн нөхцөл болно.

Үндэсний баялаг, эдийн засгийн чадавхид эд материалын биш нөөцийн чадавхи хамаарагдана. Монгол орны ард түмэн, үндэстэн ястны дунд бүрдэж тогтсон аж ахуй, соёлын, ардын давтагдашгүй сайхан уламжлал, аж ахуйг эрхлэх ба удирдлагын өөрчлөгдөн шинэчлэгдэж байгаа менежмент, маркетингийн ухаан, нийгэм-улс төрийн ардчилсан чиг баримжаалал хамаарагдана. Эдгээрийн дотроос хамгийн гол бусдаас ялгагдах хүчтэй нөлөөлөл, хувьсган өөрчлөх, чадвартай нэг элемент бол шинжлэх ухааны ахицтай хөгжил юм. Одоо 100 гаруй эрдэм шинжилгээний байгууллага, их дээд сургуулийн хүрээнд олон арван мянган эрдэмтэн, эрдэм шинжилгээний ажилтан, багш нар ажиллаж байна. Улсын ба хувийн 90 гаруй дээд сургуульд болон гадаадад олон мянган оюутан суралцаж мэргэжил эзэмшиж байна. Оюуны чадавхи улам нэмэгдэж байна.

Манайд шинжлэх ухаан, оюуны чадавхийн ролийг дутуу үнэлч, эдгээрт хөрөнгө хуваарилахдаа ямагт үлдэгдлийн аргаар хандаж, түүнд нэн хангалтгүй анхаарч ирсэн ба одоо ч мөн тийм хэвээрээ байна. Зах зээлийн нөхцөлд орчин үеийн шинжлэх ухааны техникийн оюуны дэвшил чадавхийн роль, ач холбогдол улам өсөж байна. Энэхүү нөөцийн чадавхийг өөртөө шингээж, хөгжүүлж явдаг субъект нь хүн гэдгийг тэмдэглэсэн. Манай орны шинжлэх ухааны онол, практик, нийгэм улс төр, аж ахуй, хууль эрхийн зүй тогтолцоо, санхүү зээл, менежмент маркетингийн үйл ажиллагаа, мэдээллийн нийлбэр нь зах зээлийн нөхцөлд үйлчлэх аж ахуйн механизм, өөрөөр хэлбэл үндэсний баялагийн чадавхийг үр ашигтай ашиглах механизмийг бүрдүүлэх учиртай.


Нөхөн үйлдвэрлэлийн үйл явцад гүн оролцож, бүх төрлийн нөөцийг зохицуулан ашиглаж эцсийн дүнд эдийн засгийн макро микро түвшинд тэнцвэрт харьцаа балансжилтийг хангах ёстой нөөцийн чадавхи бол чухамдаа аж ахуйн механизм юм. Энэ бол үндэсний баялагийн чадавхийн ашиглалтын үр ашгийн түвшинг илэрхийлнэ.

Үндэсний баялагийн чадавхи олон талтай. Энэ нь материаллаг болон оюуны баялагийн өсөлт, бууралт тэдгээрийн ашиглалтын үр ашиг, хүний хөгжлийн түвшин, байгаль орчны аюулгүй байдал, манай орны эдийн засаг, нийгэм улс төрийн тогтворжилт эдгээрт үзүүлэх гадаад нөлөө зэргийг тодорхойлно.

Зах зээлийн нөхцөлд аль ч улсын эдийн засаг олон улсын интергалчлал, глобалчлалын гольдрогт татагдаж ойртох боллоо. Монголын эдийн засгийн өнөөгийн хүндрэл, өвөрмөц байдал нь гадаадын зээл тусламж, хөрөнгө оруулалтыг татах зайлшгүй шаардлагыг нөхцөлдүүлж байна. Энэ нь манай орны эдийн засгийн чадавхыг бэхжүүлэх нэг гол хүчин зүйл болж байна. Гадаад хүчин зүйлийг бодолцон үндэсний баялагийн бүдүүвч 2-оор харуулав.

Үндэсний эдийн засгийн чадавхийг бүрдүүлэх ашиглах загварт гадаад бүх хүчин зүйлийг бодолцох ёстой. Гадаад хүчин зүйлийн нөлөөллийг хоёрдугаар загварт (бүдүүвч 2) гадаад орчинтой холбоотой үндэсний баялагийн зарим элементүүд тэдгээрийн харилцан үйлчлэлийг тусгасан болно. Зах зээлийн харилцаанд гүнзгий орох явцад манай оронд байгалийн нөөцийг ашиглах, эдийн засгийн бүтцийг өөрчлөх, дэд бүтцийн салбарыг хөгжүүлэх, үйлдвэрлэлийн техник технологийг боловсронгуй болгоход гадаадын зээл тусламж, хөрөнгө оруулалтыг өргөтгөж зохистой ашиглах, нээлттэй эдийн засгийн бодлого явуулах, олон улсын зах зээлд гарах, экспортын хэмжээг нэмэгдүүлэх явдал шийдвэрлэгч хүчин зүйл болно.

Ялангуяа А элементийн хувьд аж ахуйн амьдралын нөхцөлд эдийн засгийн чадавхийн гадаад орчинтой харьцах чухал харилцаа нь шинжлэх ухаан-техник, технологийг хөгжүүлэх нэвтрүүлэх, шинэ нөхцөлд ажиллах боловсон хүчнээ сургах, хүн амынхаа хөдөлмөр, сэтгэл зүйн бэлтгэлийг хангах зэргээр оюуны чадавхаар дамжин өргөжинө.



Тайлбар: 1. Биет нөөц; А. Биет биш нөөцийн чадавхи; 2. Ашиглагдаж байгаа биет нөөц; Б. Чадавхийн ашиглалтын үр ашиг; 3. Чадавхи ашиглалтын үр дүн

Эднээс үзэхэд олон тооны цогц үзүүлэлтүүд дээр суурилж үндэсний баялагийн чадавхийн тоо чанарын үнэлгээг өгөх ёстой. Энэ чиглэлээр судалгаа, шинжилгээг гүнзгийрүүлэн хийхэд тус нэмэр болох болов уу гэж үзэж 1 ба 2 загвараар үндэсний баялагийн чадавхийн гол элементүүдийн харилцан холбоог харуулах оролдлого хийв. Үндэсний баялагийн чадавхи нь нилээд хэдэн хэмжүүрээр үнэлэгдэх магадлал бүхий хэмжээ юм.

1. Үндэсний баялагийг ашигласны үр дүнд бүтээгдсэн үндэсний нийт бүтээгдэхүүн (ҮНБ) эсвэл тодорхой хугацааны (жилд) материаллаг баялаг, үйлчилгээний хэрэглээний ба хуримтлалын сан нь **эдийн засгийн хэмжүүр** юм.
2. Улс орны нийгмийн хөгжил (үндэсний баялгийн жигд хуваарилалт), хүний хөгжлийн түвшин, байгаль орчны нөхцөл, эдийн засгийн аюулгүй байдлын хангалт, нийгмийн дотоодын тогтворжилт зэрэг **нийгмийн хэмжүүр** болно.

II. Үндэсний баялагийн ашиглалт, үр ашиг

Үндэсний баялагийн биет чадавхийн хуримтлал нь хоёрдмол үр дагавартай. Нэг талаас байгаа нөөцийг дээд зэргийн үр ашигтай, хэмнэлтэй ашиглах нь эдийн засгийг дотроос нөхөн тэтгэж, цаашдын эрчимтэй өсөлтийг хангах нөхцлийг бүрдүүлнэ.

Ингэснээр хувийн өмчийн хэвшил давамгайлсан эдийн засгийн чөлөөт тогтолцоотой, аж ахуйн нэгж бүр нь биеэ даасан хэдий ч эдийн засгийн чадавхаа алс хэтийн гүнзгий нэгдмэл бодлого, тодорхой чиг баримжаалалтай зөв бүтэц зохистой харьцаа, ухаалаг тооцоотой бүрдүүлж, шинжлэх ухаан, техник технологийн хурдан хөгжил, нийгэм, иргэн бүрийн өөрөө амьдрах идэвхжил, бүтээмжийн өндөр түвшинд тулгуурлан үндэсний баялагийг дээд зэргийн үр ашигтай ашиглах болно. Ингэснээр дэлхийн олон улсын зах зээл дээр гарч, өрсөлдөх эрэлт хэрэгцээг хангах чадварыг бий болгоно.

Нөгөө талаас анхнаасаа үндэсний баялагийн эдийн засгийн чадавхаа зохистой бүтэц, тэнцвэрээ бүрдүүлж үр ашигтай ашиглаагүй, шинжлэх ухаан, техник технологийг цаг үетэй холбон дорвитой хөгжүүлээгүй нөхцөлд тухайн орон юу л байгаа бүхий л нөөцөө бэлэнчлэн хэмнэлтгүй үрэлгэн хэрэглэж аяндаа эдийн засгийн алдагдал хомсдолд автан бусдын тусламж дэмжлэгэнд шүтэн, нөлөө бүхий орны зах зээлийн "хар хайрцаг"-ны бодлогын нөлөө хязгаарлалтанд орж тэдэнд байгаа түүхий эдээ нийлүүлэгч болж хувирдаг. Ийм орны эдийн засгийн тэнцвэр, балансжилт алдагдаж аажимдаа хөгжлийн зогсонги байдалд ордогийг дэлхийн буурай хөгжилтэй нилээд орны гашуун туршлага нотолж байна.

Нийгмийн нөхөн үйлдвэрлэлийн явцад эдийн засгийн биет нөөцийг ашигласны үр дүнд үндэсний нийт бүтээгдэхүүн, үндэсний баялаг нэмэгдэж, улмаар ард түмний амьдралын түвшин дээшилж байх зүй тогтолтой.

Монголын ДНБ-ний үзүүлэлт
(тэрбум төгрөг, 1993 оны үл хөдлөх үнээр)

№		1990	1995	1996	1997	1998
1.	Дотоодын нийт бүтээгдэхүүн	208.6	180.8	185.0	192.5	199.2
2.	Үндэсний нийт бүтээгдэхүүн	186.8	169.8	175.0	181.8	188.2
3.	Нэг хүнд ноогдох ДНБ (төг)	100526	78807	79423	81457	83130

1994 оноос манай оронд эдийн засгийн уналт зогсож, тогтворжих хандлагад орсон. ДНБ 1996-1998 онд 2.4-3.5 хувь өссөн, харин 1999 оны урьдчилсан гүйцэтгэлээр 1.6 хувь өсөж ахиад уналт ажиглагдлаа. ДНБ нийт ашиглаж байгаа биет үндэсний баялаг буюу үндсэн ба эргэлтийн капиталд харьцуулсан харьцаа нь үйлдвэрлэлийн эдийн засгийн үр ашгийг харуулна. 1998 оны байдлаар ДНБ оны үнээр 875.8 тэрбум төгрөг, үндсэн капитал (бүрэн биш тоогоор) 1516.7 тэрбум төгрөг, тэгвэл үндсэн капиталын нэг төгрөгт 0.58 мөнгөний ДНБ оногдож байна. Энэ туулын хангалтгүй үзүүлэлт. Зах зээл хөгжсөн орнуудад үндэсний баялагийн чадавхийн ашиглалтын үр ашгийг хэдэн гол нийтлэг шалгуураар үнэлж авдаг. Тэдгээр шалгууртаа үндэслэн ирээдүйн хөгжлийнхөө чиг баримжааг тодорхойлдог. Тийм шалгуур үзүүлэлт:

- а. Хөдөлмөрийн нөөцийн үр ашиг, хөдөлмөрийн бүтээмж,
- б. Бэлэн ашиглагдаж байгаа капитал (үйлдвэрлэлийн үндсэн капитал) ашиглалтын үр ашиг - түүний нэг төгрөгт ноогдох үндэсний бүтээгдэхүүн,
- в. Анхдагч нөөцийг (материал, түүхий эдийг) ашигласны үр ашиг - материал багтаамж, эрчим хүч багтаамж юм.

Эдгээр үзүүлэлт нь хоорондоо харилцан бие биендээ нөлөөлнө. Эхний хоёрыг тогтвортой өсгөж сүүлчийнхийг бууруулж байж л улс орны эдийн засаг хөгжиж үйлдвэрлэлийн үр ашиг дээшилж байдаг. 60-аад оноос хойшхи хугацаанд судалгаа хийж үзэхэд манай орны материаллаг үйлдвэрлэлийн хүрээнд ашигладаг буй үндсэн ба эргэлтийн капиталыг бүрдүүлэхэд гадаадын зээл тусламж ихээхэн, ер нь гол рольтой байлаа. Манайд импортолсон хөдөлмөрийн зарцуулалтын өртгөөс 3-12 дахин хурдан өсөж байлаа. Гэхдээ түүний үр ашиг, өгөөж ямар байв гэдгээс эдийн засгийн хөгжлийн чанар шалтгаална.

1. Ажиллах хүч, оюуны чадавхийн ашиглалтыг эцсийн дүнд хөдөлмөрийн бүтээмж, түүний үр өгөөжөөр хэмжинэ. 1990 оныг хүртэл сүүлийн 30-аад жилд хөдөлмөрийн бүтээмж туйлын хэмжээгээр нэмэгдэж байсан боловч тогтвортой болж чадахгүй, харин 1970-аад оноос өсөлтийн хурдац нь эрс буурч байлаа.

Зах зээлд шилжиж байгаа сүүлийн 10 жилд улсын хэмжээгээр ба үйлдвэр аж ахуйн газруудад хөдөлмөрийн бүтээмжийг тооцох, судлах ажил бараг хийгдэхгүй боллоо. Энэ бол том алдаа юм. Бидэнд байгаа статистикийн тоо материалыг ашиглаж эдийн засгийн бодит салбарт ажиллагчдын хөдөлмөрийн бүтээмжийг тооцох оролдлого хийлээ.


№		1995	1996	1997	1998
1	Бүх ажилчид (мянган хүн)	794.7	791.8	788.3	809.5
2	ДНБ (1993 оны зэрэгцүүлэх үнээр, сая төгрөг)	180755.4	185047.7	192508.3	199205.2
3	Хөдөлмөрийн бүтээмж (төг)	227451.1	233705.1	244206.9	246084.2

1998 оныг 1995 онтой харьцуулахад ДНБ-ээр тооцсон бүтээмж 8.2 хувиар нэмэгдсэн. Аж үйлдвэр, ХАА, ИХ барилгын салбараар хөдөлмөрийн бүтээмжийг үйлдвэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүнээр (1993 оны үнээр) тооцож үзүүлбэл:

№	Салбар	1995	1996	1997	1998
1	Ажиллагчид (мянган хүн): а. Аж үйлдвэр б. ХАА в. Барилга	108.13 54.3 29.5	104.63 58.1 29.7	100.43 74.5 27.4	97.9 394.1 27.5
2	Үйлдвэрлэсэн ДНБ (сая төг) а. Аж үйлдвэр б. ХАА в. Барилга	61256.7 65602.5 3329.3	60031.5 668713.6 3497.4	62672.9 71985.7 3326.0	64741.1 74217.3 3149.7
3	Хөдөлмөрийн бүтээмж (төг) а. Аж үйлдвэр б. ХАА в. Барилга	566666.9 185160.8 112857.6	573914.9 191883.8 117757.5	624232.0 192218.2 121386.9	661298.3 188320.9 114534.5

1998 оныг 1995 онд харьцуулахад аж үйлдвэрийн салбарт 16.7%, ХАА-д 1.7%, барилгад 1.5% өсчээ. Харин энэ хугацаанд ажиллагчдын тоо буурсан нь хөдөлмөрийн бүтээмжийн тоон үзүүлэлт нэмэгдэхэд нөлөөлсөн. Зах зээл хөгжсөн орнууд хөдөлмөрийн бүтээмжийг ямар ч нөхцөлд өргөтгөсөн нөхөн үйлдвэрлэл явуулах зайлшгүй нөхцөл гэж үзэж, түүний өсөлтийг бууруулахгүйг эрмэлздэг. Тэгэхдээ хөдөлмөрийн бүтээмж, цалингийн зохистой харьцааг барьж байхыг чухалчлан үздэгт хамаг учир байна. Манай орон зах зээлийн харилцааг гүнзгийрүүлэхдээ аж ахуйн нийгмийн бүх хүрээнд хөдөлмөрийн бүтээмжийг хамгийн гол хүчин зүйл болгох ёстой.

Манай оронд 90-ээд оны эхэн хүртэл ажиллах хүч дутагдалтай байлаа. Гэтэл одоо ажилгүйдэл бодит зүйл боллоо. Үүний гол шалтгаан нь: **а.** Эдийн засгийн бодит салбарт уналт, ажлын байрны хомсдол, **б.** Залуу ажиллах хүчнийг хөдөлмөрт бэлтгэх тогтолцоо, уялдаа алдсан, **в.** Зах зээлийн нөхцөлд ажиллаж байх, амьдрах ухамсар зөн олонд төлөвшөөгүй. Ажиллах хүчний ашиглалтаас улсынхаа эдийн засгийг хөгжүүлэх асар их нөөц боломж алдаж байна. Зөвхөн дээр тооцоолсон хөдөлмөрийн бүтээмж, бүртгэгдсэн ажилгүйчүүд - 38, мянган хүнээр бодоход наад зах нь жилд 9.4 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн алдаж байна. Хөдөлмөрийн бүтээмжийг зөвхөн материаллаг баялагийг бүтээгчид төдийгүй "цагаан захтнууд"



дээр нийтэд нь тооцох, үнэлэх, урамшуулах тогтолцоо аргагүйг боловсруулах, хэрэгжүүлэх шаардлагатай байна.

2. Зах зээлийн харилцаагаар хөгжихөд Монголын нэг давуу тал бол онгон төрхөөрөө байгаа өргөн уудам нутаг дэвсгэр, газрын хөрсөн доорх эрдэс түүхий эдийн баялаг юм. Газар байгалийн эрдэс, түүхий эдийн баялагийг үр ашигтай зохистой ашиглалтаас манай орны болон бус нутгийн эдийн засгийн хөгжил шалтгаална. Өнөө болон ирээдүйн эрэлт ихтэй эрдэс, баялагийг нэн тэргүүнд ашиглах нь чухал.

Эрдэс баялагийн нөөцийг дотооддоо боловсруулж эцсийн бүтээгдэхүүн гаргах, эсвэл түүхий эдийн байдлаар гадаадад гаргах хоёр арга зам бий. Үүнээс аль үр ашигтайг нь сонгох шаардлагатай. Одоогийн байдлаар аж ахуйн эргэлтэд зэс, молибден, алт, нүүрс, хайлуур жонш зэргийг илүүтэй олборлон ашиглаж байна. Сүүлийн жилд манай улс алтнаас бусад ашигт малтмалын орд газрыг бараг ашигласангүй. Харин алтыг илүүтэй илрүүлж олборлоход сүрхий шунахай дайрч эхэлсэн, үүнийг дагаж байгаль орчноо сүйтгэж байна. 1998 онд 90 гаруй үйлдвэр компани нийтдээ 11.1 тн алт (бохиороор) 1999 онд 11 тн-ийг олборлосон.

Эрдэс баялгийн нөөцийг ашиглахад гадаадын хөрөнгө оруулалтыг ахицтай ашиглах боллоо. Энэ зайлшгүй хэрэгтэй. 1990-1999 онд энэ салбарын 66 аж ахуйн нэгжид нийт 19.9 сая ам. долларын хөрөнгө оруулалт орсон байна.

Үйлдвэрлэлийн чадавхитай (хэмжээ, чанараар) орд газруудыг ашиглахад гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг татах нь хамгаас чухал.

Эрдэс түүхий эдийн баялагийн ашиглалтыг байгаль экологийн хувьд хамгийн оновчтой байдлаар аж ахуйн эргэлтэнд оруулах бодлогыг боловсруулж тууштай хэрэгжүүлэхгүй бол сөрөг үр дагавар их байгаа нь өнөөгийн тулгамдсан асуудал боллоо.

3. Эдийн засгийн биет чадавхийн ашиглалтын үр ашиг манайд туйлын хангалтгүй байсан зах зээлд орсноор бүр ч дордлоо. Сүүлийн бүрэн бус мэдээгээр зөвхөн 15.9 мянган үйлдвэр аж ахуйн газарт 1521.1 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгө байгаагийн 38.4 хувь нь төрийн секторт, 51.9 хувь нь хувийн секторт, үлдэх нь холимог секторт харъяалагдаж байна. Түүчлэн үндсэн хөрөнгийн 60.2 хувь нь компаниудад, 5.9 хувь нь нөхөрлөлд, 7.6 хувь нь хоршоонд, 7.8 хувь нь хувиараа эрхлэх аж ахуйд, үлдэх нь бусад аж ахуйн нэгжид хамрагдаж байна. Эндээс үзэхэд үндсэн хөрөнгийн зонхилох хэсэг нь томоохон аж ахуйн нэгжид төвлөрсөн байна. Үйлдвэрлэлийн үндсэн капиталын үр ашиг нь фонд өгөөмж, хүчин чадлын ашиглалтаар тодорхойлогдоно. ДНБ-ээр бодоход фонд өгөөмж нь 0.58 мөнгө байгаа нь үндсэн капиталын ашиглалтын үр ашиг хангалтгүйг илэрхийлнэ. Материаллаг үйлдвэрлэлийн салбарт үндсэн капиталын болон хүчин чадлын ашиглалт нэн хангалтгүй байна. Аж үйлдвэрийн салбарт үйлдвэрлэлийн суурьлагдсан хүчин чадлын ашиглалт дундажаар 15 орчим хувьтай байна. Үүний дотор мах боловсруулах үйлдвэрийн хүчин чадлын 75 хувийг, ноолуур боловсруулах үйлдвэрүүдийн

хүчин чадлын 80 хувийг ашиглахгүй байна. Зөвхөн энэ хоёр салбарт хүчин чадлын ашиглалт муу байгаагаас 150 сая ам. долларын экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломж алджээ.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний өсөлтийн хувь сүүлийн гурван жилд 4.4, 3.3, 1.1 болж буурсан нь мөн л хүч чадлын ашиглалттай холбоотой.

Материалын зардал үндэсний нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлээс хэд дахин илүү хурдан өсөж, материал багтаамж жилээс жилд нэмэгдсэн. Үндэсний нийт бүтээгдэхүүний төгрөг тутамд ногдох материалын зардал аж үйлдвэр, барилгын салбарын аж ахуйн нэгжүүдэд улам түргэн өсөж байна.

Одоо манай улсад эргэлтийн капиталын эргэлт их удаан жилдээ бараг нэг удаа (307 хоногт) л байна. Энэ нь аж ахуйн нэгжүүд ашиг орлогоо үйлдвэрлэлийн үйл ажиллагааны үр дүнгээр биш, зөвхөн ганзагын наймаа, үнийн өсөлтөөр олж авч байгааг гэрчилнэ.

Энэ бүхэн нь урьд өмнийн ба өнөөгийн нөхцлөөс шалтгаална. **Нэгдүгээрт:** Манай эдийн засаг хямралд бүр эртнээс орсныг харуулж байна. **Хоёрдугаарт:** эх орондоо болж байгаа биет ба оюуны чадавхийг идэвхижүүлэн хөгжүүлэн тэдгээрийг үр ашигтай ашиглахад тулгуурласан эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх алс хэтийн хараатай бодлого явуулах хэрэгтэй байна. Эдийн засагт өөрийгөө дотроос нь тэтгэх харилцан нөхөх бүтцийг бүрдүүлээгүй байсан. **Гуравдугаарт:** Зах зээлийн бодит эрэлт нийлүүлэлтэнд тохирсон аж үйлдвэржилт, хөдөө аж ахуйн хөгжлийн бодлого явуулаагүй аль ч салбарт үйлдвэрийн ганцаарчилан дангаараа ноёрхох хүч чадлыг бий болгож, түүнийгээ бүрэн ашиглаж чадахгүй байгаа. Үйлдвэр аж ахуйн оновчтой хэмжээг ердөө тооцохгүй хэвээр байна. **Дөрөвдүгээрт:** арвилан хэмнэлтийн бодлогыг үйл ажиллагааны хэвшил болгоогүй, үр ашиг багатай, зардал ихтэй механизмаар аж ахуйг эрхэлж зөвхөн үнийн өсөлтөөр орлого, ашиг олж байна. **Тавдугаарт:** урьд нь өмчийг эзэмших үйлдвэрлэлийн эцсийн үр дүнг өөрийн болгох үйл явц зохих ёсны эзэндээ хүрээгүй байсан. Үйлдвэрлэлийн үндсэн нэгж дээр аж ахуйг жинхэнэ зах зээлийн эрэлт хэрэгцээнд зохицуулан эдийн засгийн агуулга зориулалтаар нь өөрийн чиглэл, урамшуулалтайгаар эрхлэн хөтлөх боломжгүй байсан одоо ч тэр хэвээр үргэлжилж байна. **Зургадугаарт:** Манай үйлдвэр нэгжүүдийн техник, технологийн түвшин орчин үеийн шинжлэх ухааны техникийн дэвшлээс харьцангуй хоцорсон түүний нөхөн шинэчлэл удаан явагдаж, одоо шинээр байгуулагдсан хувийн хэвшлийн жижиг аж ахуйнуудын техник технологийн түвшин доогуур байгаатай болбоотой. **Долдугаарт:** зах зээлд шилжсэнээр аж ахуй хоорондын болон салбар хоорондын уялдаа харилцан холбоо, хоршилт алдагдсан. **Наймдугаарт:** аж ахуйн зонхилох нэгжид санхүү, төлбөрийн чадвар доройтсон, өрийн гинжин сүлжээ үүссэн явдал олон үйлдвэр аж ахуйг үйл ажиллагаагаа зогсооход хүргэлээ.

Урьд өмнө нь манайд хөдөлмөр, материал, санхүүгийн болон байгалийн нөөцийг дэндүү элбэгжүү, үр ашиг багатай ашиглаж, хэмнэлтгүй, зардал ихтэйгээр аж ахуйг

эрхлэн хөтөлж, эцсийн үр дүнд эх орноо гадаадаас хараат, зээл тусламжинд шүтэн бишрэгч болгосон нь хэзээ ч мартагдахааргүй түүхэн сургамж боллоо. Өнгөрсөн нь өөрийн алдааг ирээдүйд давтуулахгүйн тулд одоо ч ямагт сургаж байдаг гэсэн мэргэн үгийн утга учрыг санууштай.

Зах зээл үйлдвэрлэл, бизнесийн үйл ажиллагаанд үндэсний баялагийн чадавхийн элемент (хөдөлмөр, капитал, газар) бүрийг үр ашигтай ашиглаж, өрсөлдөөнийг давж, хэрэгцээг хангах чадвартай, ахуй ашиг орлоготой, үйл ажиллагаагаа явуулдагаараа давуутай.

Үндэсний баялагийн динамикт манай орны эдийн засгийн чадавхи, түүний нөхөн үйлдвэрлэлийн үр ашиг агуулагдаж байдаг. Иймээс зах зээлийн харилцаанд шилжих, эдийн засгийн бүтцийг зохистой өөрчлөх түүний бодит угтвар нөхцлийг бүрдүүлэх цаашдын хөгжлийн стратегийг боловсруулахдаа үндэсний баялаг түүний бүрэлдэхүүн хэсэг-эдийн засгийн чадавхийн ашиглалтыг эрс сайжруулах талаар шинжлэх ухааны шинэ судалгаа хийж дээд зэргийн үр ашигтай ашиглах чиг баримжаалал зайлшгүй шаардлагатай.

Үндэсний баялаг, эдийн засгийн чадавхийн өсөлт, өргөжилтийг тодорхойлохын тулд зарчмын шинэ арга зүйг боловсруулах шаардлагатай. Энд баримтлах гол зарчмууд нь:

Нэгдүгээр зарчим: Баялагийн аль ч элементэнд зардлыг үндэслэн өртгийн үнэлэлт өгөх үүднээс хандаж болохгүй. Тэгвэл тэр нь инфляци, үнийн өсөлтийн нөхцөлд эдийн засгийн тооны үзүүлэлтүүд аяндаа нэмэгдээд байна. Иймээс хуримтлалын үйл явцад тухайн баялагийн гүйцэтгэж байгаа үр дүнг тусгаж үнэлэх ёстой.

Үйлдвэрлэлийн үндсэн капиталыг хуримтлалын үр дүнгийн үүднээс юуны урьд тэдний чадавхийн өсөлт өөрөөр хэлбэл бүтээгдэхүүн үнэлэх чадвараар нь үнэлнэ.

Байгалийн баялагийг түүнийг олборлоход гардаг түргэн өсч байгаа зардлаар нь биш, түүний хэрэгцээний өртгийн бууралтыг тусгасан, "орлого бий болгох хүчин зүйл" ба рентийн үнэлгээний зарчмаас хандах ёстой. Зах зээл нь манайд урьд хэвшиж байсан зардлын механизмын эсрэг үйлчилнэ.

Хоёрдугаар зарчим. Баялагийг тодорхойлохдоо дансанд бүртгэгдсэн ашиглалтгүй үхмэл үндсэн ба эргэлтийн капитал зэргийг оруулсан хуурамч эд хөрөнгөнөөс цэвэрлэх ёстой. Ийм элементүүд бүх үйлдвэр аж ахуйн газарт данс бүртгэлд асар их хэмжээтэй байсан, одоо ч байна. Илүүдэл хэрэгцээгүй үндсэн хөрөнгө, нормативаас хэтэрсэн хэрэгцээгүй эргэлтийн хөрөнгө, гололдол бүтээгдэхүүн, дуусаагүй үйлдвэрлэл, дутуу ашиглаж байгаа хүч чадал, ийм зүйл гэрийн аж ахуйд ч бий.

Ер нь одоо байгаа материаллаг нөөцөө зөв тодорхойлохын тулд дахин үнэлэлтийг чанартай, нэгдсэн журамтай хийх ёстой. Өмч хувьчилахад бэл бэлчинтэй хүмүүсийн

хуйвалдаан явагдахаас болгоомжлохгүй бол эх орон, ард түмэн туйлын их хохирч цөөн хэсэг нь завшина.

Гуравдугаар зарчим. Үндэсний баялагийн хэмжээг тодорхойлохдоо нөөцийн хэмжээг тусгайлан боловсруулсан ухраасан тооллого /бүртгэл/-ийн аргын тусламжтайгаар нөөцийн төрөл бүрээр биет хэмжигдэхүүнээр хэмжиж байгалийн баялагийн хэмжээг гаргаж үнэлгээ өгөх.

Одоо манайд үнэндээ ийм үнэлгээ хийгдээгүй байна. Энэ арга нь хэрэглэсний хирээр байгалийн нөөцийн хэмжээнээс хасаж хорогдуулж байдаг. Тэднийг аж ахуйн эргэлтэнд оруулах технологи, эдийн засгийн бололцоо өргөжих тутам бодит нөөцийн хэмжээний тухай мэдэгдэж буй мэдээ аяндаа хорогдох магадлалтай.

Эдийн засгийн чадавхи олон талтай. Энэ нь материаллаг болон оюуны баялаг тэдгээрийн ашиглалтын үр ашиг, хүн амын нийгмийн хөгжлийн төвшин, тогтворжилт байгаль орчны аюулгүй байдал, эдийн засаг, улс төрийн гадаад нөлөө зэргийн нийлбэрээр тодорхойлогдоно. Эдгээрээс гадна цаг уурын нөхцөл, аж ахуйг эрхлэн хөтлөх механизм зэрэг статистикийн үзүүлэлтээр хэмжигдэхгүй, гэхдээ эдийн засгийн чадавхид нөлөөлдөг хүчин зүйлүүд байна. Энэ бүхнээс үзэхэд олон тооны цогц үзүүлэлтүүд дээр үндэслэж эдийн засгийн чадавхийн үнэлгээг өгөх ёстой.

Хорвоо хэдийгээр дүүрэн баялаг, мөнгө байна түүнийг цуглуулж авахад ухаан санаа, ухаалаг үйл ажиллагаа хэрэгтэй гэж нэг гүн ухаантан хэлсэн байдаг.

Манайд одоо бэлэн байгаа үйлдвэрлэлийн капитал, хүчин чадлыг бүрэн ашиглавал хамгийн багаар бодоход дотоодын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг олон тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж болно.

Ингэхээр юуны урьд өмчийн хэлбэрийг харгалзахгүй бүх үйлдвэр, нэгжийн хүчин чадлын бололцоотой хэмжээгээр бүрэн ашиглах нь чухал. Энэ зорилгоор:

- эдийн засагт хөдөө аж ахуй, байгалийн эрдэс түүхий эдийн нөөцдөө суурилсан, дотооддоо хоршилт, нөхөн тэтгэх нягт холбоотой, дотоодын зах зээлийн хэрэгцээг хангах, экспортын нөөцийг нэмэгдүүлэх хамгийн зохистой бүтцийн өөрчлөлт хийх.
- Тулгуур салбар, үйлдвэрлэлийн тогтвортой хөгжлийг хангаж чадахуйц дэд бүтцийг бүрдүүлэх.
- Одоо ажиллаж байгаа үйлдвэр, аж ахуйн үйлдвэрлэлийн аппарат технологийг нэн даруй шинэчлэл хийх.
- Жижиг дунд үйлдвэрийг одоогийнх шиг урсгалаар биш, зах зээл, төрийн захиалгын үндсэн дээр ирээдүйг нь нарийн бодсон тодорхой чиглэлтэй, орчин үеийн шинжлэх ухаан техникийн дэвшил дээр тулгуурлан хөгжүүлэх. Цаашдаа жижиг дунд аж ахуйтнууд нь том аж ахуйтай болон хоорондоо хорших үйл ажиллагаанд зайлшгүй орно.
- Бусад оронд түүхий эдийн нийлүүлэгч байснаар манай орон олигтой хөгжихгүйг түүх аяндаа гэрчилнэ. Иймээс түүхий эдийг эмх замбараагүйгээр

гадаадад гаргадагийг аль болохоор хатуу хязгаарлаж, зах зээл дээр гарах чадвар бүхий эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд бүрэн шилжих шаардлагатай. Түүхий эдийг гаргаснаар их алдагдалд орно.

Зөв эргэлтийг дагасан хөрөнгө оруулалтын бодлого явуулж, эдийн засгийн чадавхийг зохистой ашиглах, сайжруулахад чиглүүлэн гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх нь чухал. Одоогийн хамтарсан аж ахуйнууд манай эдийн засагт ямар хувь нэмэр оруулж байгааг судлан дүгнэлт өгөх шаардлагатай болов уу. Зарим нь эзний эрх ашгийг дэндүү баримталж, хэтэрхий ноёрхолтой, манай эдийн засагт өгөөж багатай нь мэдрэгддэг. Хамтын үйлдвэрүүдийн үйлдвэрлэл манай нутаг дэвсгэр дээр явагдаж, бүтээгдэхүүний хэрэглээ нь бусад орны нутагт явагдаж, нэмүү бүтээгдэхүүнээ бид алдаж түүнээсээ эргүүлж хүүтэй зээл авч байгаа нь нууц биш. Энэ мөн үү?

Гадаадын хөрөнгө оруулалт тал бүрийн үр өгөөжтэй байх зарчим дээр явагдана. Үүнийг нөгөө талаар их хөрөнгө оруулалтын цаана улс төрийн болон "хар хайрцагны" бодлого агуулагдаж байдаг нь манай түүхэн сургамж болж байна. Засгийн газар ч, төсөв байгууллагууд ч, бизнесменүүд ч гадаадын харилцагч түншүүдтэй гэрээ хэлэлцээр харилцан ашигтай тооцоог тэгш эрхийн үндсэн дээр ул суурьтай зоримог хийх арга ухаанд суралцах хэрэгтэй байна. Үүнээс их алдаж байгааг амьдрал харуулж сургамжилж байна. Хөрөнгө оруулалтыг удирдахад Засгийн газрын харъяанд хөрөнгийн банк байгуулж, түүгээр дамжуулан бодлого хэрэгжүүлэх нь ач тустай болно.

Газар байгалийн нөөц ёстой л яндашгүй баялаг. Зах зээл хөгжсөн аль ч орон энэ баялаг руугаа шунаг цэвдэг сэтгэлээр харьцаж, хожим нөхөшгүй гарз хохирол учруулсандаа одоо гэмшдэг. Манай онгон төрхөөрөө байгаа газар, байгалийг болдогсон бол тэр хэвээр нь дархалмаар санагддаг. Үйлдвэрлэх хүчийг хөгжүүлэх, ашиглахдаа ашгаа бодож ой, ан, алт бусад эрдэс түүхий эдрүүгээ шунаг сэтгэлээр дайрч, байгаль эхдээ их хөнөөл учруулж эхэллээ. Урьд нь жонш, вольфрамыг хээрийн аргаар замбараагүй олборлосноос сэглэгдсэн газар ямар их билээ. Одоо алтны ордууд яг л тийм болно. Эцсийн үр дүнд хоосорсон агуй, ухмал нүхнүүдтэй үлдэнэ гэхээс айдас хүрдэг юм. Газар байгалийн нөөцөө хүн-байгаль-үйлдвэрлэл гэсэн баримжаатайгаар байгаль орчинд зохицсон шинжлэх ухааны үндсэн дээр боловсронгуй технологитойгоор ашиглах ёстой. Цэвэр байгаль дэвшилтэт технологи гол зүйл.

Байгалаас ашигласан нөөцөө алдагдал хаягдалгүй иж бүрэн ашиглах тийм технологи хэрэгтэй. Нүүрсийг түлж шатаахаас өөрөөр ашиглахгүй байна. Гэтэл түүнийг боловсруулж хатуу, шингэн түлшнээс эхлээд янз бүрийн бүтээгдэхүүн хийх тухай манай эрдэмтэд, шинийг санаачлагч инженерүүд олон жил ярив, одоо хүртэл хэрэгжээгүй. Байгалийн нөөцийг төрийн хатуу бодлого, хяналтын дор ашиглах ёстой.

Орон нутгийн захиргаа, жижиг аж ахуй бүр гадаадынхантай нийлж дураараа (одоо

алт олборлолт дээр гарч байгаа шиг) дайрах явдлаас болгоомжлох, хязгаарлах нь нэг хэсэг хугацаанд зүйтэй байх.

Эд материал, байгалийн ямар ч нөөц байлаа гэсэн зөвхөн хүний хөдөлмөр, эрдэм оюуны нөөцийн үйлчилгээтэй холбогдож жинхэнэ баялаг болж үр ашгаа өгнө. Иймээс хөдөлмөр, оюуны нөөц бол бүтээлч баялаг.

Зах зээл хүний амьдрах чадвар, авъяас бэлгийг шалгаруулж, оюуны чадавхийг өрсөлдүүлж дээд зэргээр ашиглахад үнэлдэг. Энэ ч өнөөгийн манай амьдралаар батлагдаж байна. Харьцангуй бага хугацаанд цөөн ч гэсэн авъяаслаг залуу бизнес хийгчид, менежерүүдтэй болж эхэллээ. Залуучуудын хөдөлгөөн, эрмэлзлэл өрнөж байна. Хөдөлмөр оюуны чадавхийг онцгой анхаарч бүрэн ашиглах асуудал зүй ёсоор тавигдаж байна. Авъяаслаг залуучуудаа зах зээлийн төрөл бүрийн мэргэжлээр гадаад дотооддоо шамдуулан бэлтгэх. Энд эцсийн дүнд Монголын төлөө сэтгэлтэй, монгол сэтгэхүйтэй л сэхээтнүүд байх ёстой. Манайх дээд, тусгай дунд боловсролтой мэргэжилтний тоогоор харьцангуй дээгүүрт ордог. Гагцхүү тэдний сэтгэн санаачлах хөдөлгөөнийг зөв залж чөлөөтэй хөгжүүлээгүй, оюуны хөдөлмөрийн үр дүнг үнэлж чадаагүйд хамаг алдаа байгаа юм.

Шинжлэн ухаан, оюуны сэтгэлгээ, санаачлагийг ивээн тэтгэн, үнэлж урамшуулж, хөгжүүлэхгүйгээр улс орноо зах зээлийн талаар хөгжүүлэх тухай санахын ч хэрэггүй. Өөрийн орныхоо өвөрмөц онцлогийг агуулж, шинжлэх ухааны үндэслэлтэй шийдвэрлэх боловсруулбал зохих үй түмэн асуудал нээлттэй хэвээр байна. Үүний нэг талаас төр, засаг онцгой анхаарал тавих, нөгөө талаас санаачлага, зориг тэвчээр гаргаж ажиллах цаг болсон.